



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар A/348

Улаанбаатар хот

**Арилжаанд оролцох эрх шинээр
олгох тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтууд болон “Вантэйж капитал ҮЦК” ХХК-ийн 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 010 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн “Вантэйж капитал ҮЦК” ХХК (Б.Гүнбилгүүн)-д Үнэт цаасны арилжаанд оролцох F1X эрх, тус компанийн брокер Б.Энхсор -д Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг шинээр олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба Ч.Эрдэнэболорт тус тус даалгасугай.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Б.ДӨЛГӨӨН

1525030713